

ЭДМУНД ГУССЕРЛИЙН “ЛОГИКИЙН СУДАЛГАА” ЗОХИОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ: УТГА БА УХАМСАР

Б. Дагзмаа (Доктор Ph.D),
О. Болор-Эрдэнэ (Магистрант)
Философи, шашин судлалын тэнхим, МУИС

Түлхүүр үгс: Дан логик, идеал оршихуй, утга, психологизм, “антипсихологизм”, догдлон мэдрэхүй, цэвэр ухамсар, Би, үйл, “интенционал шинж”, трансцендентал субъект

Хураангуй: ХХ зууны философийн түүхэнд өрнөсөн нөлөө бүхий үзэл санааны хөдөлгөөнүүдийн нэг болох феноменологийг үндэслэгч Эдмунд Гуссерлийн (1859-1938) бүтээл туурвилыг феноменологийн өмнөх үе, феноменологийн үед хамааруулан ангилахын сацуу¹ феноменологи философийг нь «deskriptiv психологи», «трансцендентал феноменологи», «генетик феноменологи» хэмээн үечлэн авч үздэг ажээ. Феноменологийн өмнөх үед түүний «Арифметикийн философи» зохиол хамаардаг бол, феноменологийн үүсэл хөгжлийг «Логикийн судалгаа» зохиолтой холбон ойлгодог билээ. Уг өгүүллийн хүрээнд Гуссерлийн «deskriptiv психологийн» үзэл санаатай холбоотой зарим асуудлыг онцлон авч үзэх юм.

Э.Гуссерль анх Берлиний их сургуульд элсэн орж, тухайн үед математикийн салбарт эргэцүүллийн нарийн чанд, оновчтой байдлаараа нэрд гарсан Кронекер, Вейерштрассе зэрэг алдартай эрдэмтэдийн удирдлага доор математик судалж байхдаа математикийн философи үндэслэлүүдийг судлах зорилгоор философид хөл тавьсан гэдэг. Энэ үед хамаарах “Арифметикийн философи” зохиолдоо математикийн үндэслэлүүдийн түгээмэл уг чанарыг илрүүлэхийн тулд ухамсарыг судлаад суурь математикийн бүтэц нь психологид үндэстэй гэж дүгнэжээ. Уг зохиолд Гуссерлийн баримтласан психологизмын байр суурь Готлоб Фреге зэрэг математик-логикчидийн зүгээс шүүмжлэл хүртэж, яваандаа учир дутагдалаа ойлгож ийм үзлээс тагталзахад хүрсэн байна. Тийнхүү математик төдийгүй ерөөс логик болон танин мэдэхүйн үйл явцыг психологид үндэслэн философи тайлбар хийх боломжгүй гэж үзэх болжээ. Энэ нь эмпирик шинжлэх ухаан болохын хувьд психологи нь бүх шинжлэх ухааны үндэс суурь болж чадахгүй гэсэн Фрегегийн үзэлтэй нийцэж байв.

Ийнхүү Гуссерль шинжлэх ухааны

онолын үндэс бол психологизм (логик дахь психологизм) мөн гэдэг баримтлалыг даван туулахыг эрмэлзэж, тийм үйл ажиллагааны үр дүнд феноменологийн үндэс суурийг тавьсан «Логикийн судалгаа» зохиолууд (1900, 1901) бий болсон юм. Уг зохиолд хүний сэтгэхүйн үндсэн хууль, шинжлэх ухааны статусын тухай асуудлыг шинээр тодорхойсон нь феноменологи философи бий болох нэг шийдвэрлэх нөхцөл нь болжээ. Э.Гуссерль өөрийн судалгааны гол чиглэлийг тодорхойлохдоо: “тийм болохоор математик төдийгүй ерөөс бүх шинжлэх ухааны обьектив чанар нь психологид тулгуурласан логиктой нийцэх үү гэсэн эргэлзээ төрж байгаа юм”¹ гэсэн байдаг. Ийнхүү уг зохиолын эхний ботид логик болон танин мэдэхүйн онол дахь психологизмыг Гуссерль шийдвэртэй няцаажээ.

Түүний үзэж буйгаар бол логикийн статусыг (тэр нь онолын салбар ухаан уу эсвэл техник шинжтэй практик сургаал уу? Психологи, метафизик зэрэг бусад ухаанаас хамаардаг уу? Психологи, логик хоёрын судлагдахуун ижил үү? гэх мэт)

¹ См: Шпигельберг, Герберт. Феноменологическое движение Историческое введение. - М., 2002.

хэрхэн ойлгох тухай асуудал тухайн үеийн философидийн дуусахгүй маргааны ундрага болсон байв. Энэ тухай Гуссерль “нийтээр мөрдвөл зохих үнэнийг хувийн итгэл үнэмшлээс ялган ойлгож чадахааргүй болсон шинжлэх ухааны ийм байдал зарчмын асуудлуудыг дахин дахин шинээр шүүн үзэхэд хүргэсэн” гэж бичжээ.

Сэтгэхүйн хуулийг логик судалдаг гэсэн формал тодорхойлолт байдаг боловч үүний агуулгыг эс тайлбарлавал янз бүрээр ойлгогдож болох юм. Тухайлбал, психологистуудын үзлээр жам ёсны зүй тогтол, «сэтгэхүйн физик» дээр тулгуурлан сэтгэхүйн дүрэм журмыг судалдаг логик хэмээх ухаан бий болдог. Энэ үзлийн томоохон төлөөлөгч Теодор Липпе “логик бол сэтгэхүйн физик мөн, өөрөөр логик оршин тогтнох аргагүй”² гэж үздэг. Хэрэв сэтгэхүйн жам ёсны үйл явцыг логик судалдаг бол, тэр нь психологитой ямар нэгэн байдлаар нийцэх ёстой юм.

Гуссерль болон психологистуудын хоорондын маргаан нь логик бүтцийг психологи бүтцэд буулгаж болох уу? Логикийн процедур хүний бодит сэтгэхүйн загвар байж болох уу? гэсэн асуудлаас үүдэлтэй. Сэтгэхүйн үйл явц психик үйл явц учраас логик бол психологийн салбар мөн гэж психологистууд үздэг. Нэг жишээ дурдахад Ж. С. Милль зөрчилгүйн хууль бол гэрэл ба харанхуй, дуу чимээ ба нам гүм гэх мэт нэгэн зэрэг байх боломжгүй зүйлсийг ажиглаж дадсан байдал, бие биеэ няцааж байгаа оюун ухааны хоёр өөр төлөв хэмээн логикийг психологид захируулан тайлбарлажээ³. Түүний үзлээр логик нь үнэнийг нээдэггүй, харин үнэнд хүрэх замыг зааж өгдөг техник шинжтэй сургаал юм.

Харин антипсихологистуудын үзлээр хэрхэн сэтгэж байгааг (сэтгэхүйн жам ёсны зүй тогтолыг) биш, харин хэрхэн сэтгэх ёстойг логик судлах учиртай. Ийм үзэл санааг Гуссерль баримтлаж, логик бол “сэтгэхүйн физик биш, харин сэтгэхүйн этик байх ёстой”⁴ гэж үзжээ. Тэрээр логик нь сэтгэхүйн үйл явцыг судлах ёсгүй, эс тэгвээс хавсрага психологи болно гэж үзээд «дан

логикийг» үндэслэх зорилт дэвшүүлсэн байдаг. Үүнд, сэтгэхүйн объектив идеал-логик агуулга болон бодит-психологи үйл явц хоёрыг ялган үзэхийг шаардаж, үнэний асуудлыг сэтгэхүйн объектив агуулгатай холбогдуулан ярьдаг учраас Э.Гуссерлийг идеалист объективизмын байр суурийг баримтладаг гэж үзэж болох юм. Ийнхүү тэрээр психологизмыг субъективизм, релятивизмын нэг төрөл гэж үзээд тэдгээрийг нийтэд нь няцаах үйл ажиллагаа явуулсан юм. Түүний үзлээр үнэний тухай асуудал абсолют үнэний ойлголтод үндэслэдэг, бусад тохиолдолд үнэний тухай ярих утгагүй. Абсолют үнэн байх бололцоо, цаашлаад дор хаяж тухайн философийн дэг сургуулийн хүрээнд түүнд тэмүүлэх хүсэл зоригийг нь историцизм, психологизм, антропологизм хүлээн зөвшөөрдөггүй учраас оюун ухаанд итгэх итгэлийг нухчин дардаг орчин цагийн софист байр суурь гэж тэдгээрийг Гуссерль шүүмжлэн авч үзжээ. Түүний үзлээр бол, “үнэн бүхэн абсолют үнэн, «өөрөө өөртөө» үнэн; бурхад эсвэл сахиусан тэнгэрүүд, хүмүүс эсвэл албин чөтгөрүүд аль нь ч түүнийг бодож эргэцүүлсэн ялгаагүй, үнэн бол нэг л зүйл”⁵. Тиймээс оюун ухаантай ямар ч амьтан байсан түүний психофизик байгууламжаас үл шалтгаалан үнэн универсал шинжтэй байх ёстой ажээ.

Тийнхүү Гусселийнхээр логик нь сэтгэхүйн психик үйл явцыг судалдаггүй ба психологиос тусдаа судлагдахуунтай бөгөөд тэр нь логик мөн чанарууд, идеал оршихуй юм. Ингэхдээ аливаа шинжлэх ухаанд онолын идеал-эйдетик хэсэг байдаг учраас логик (дан логик) илүү өргөн хүрээнд ач холбогдолтой байдаг гэж Гуссерль дүгнэсэн байна. Иймээс логикийн онол нь шинжлэх ухааны сургаал (Wissenschaftslehre) мөн бөгөөд сэтгэхүйн шалтгаант холбоог психологи, харин сэтгэхүйн идеал холбоог логик судалдаг гэж Гуссерль үзсэн юм.

Сэтгэхүйг психик ертөнцөд хамааруулахыг Гуссерль няцаасан байна. Энэ нь психологизм, субъективизм, эмпиризмийг шийдвэртэй няцаасан Готлоб Фрегегийн байр суурьтай төстэй. Гэхдээ Фрегегийн математикийн платонист

² Гуссерль Э. Логические исследования. //Гуссерль Э. Сборник. - Мн. - М., 2000. - С.12.

³ Там же. - С. 15.

⁴ Там же. - С. 68.

⁵ См. об этом. Милль Д. С. Система логики силлогистической и индуктивной: Изложение принципов доказательства в связи с методами научного исследования. - М., 2001. - С. 233-236.

байр суурьтай Гуссерлийн сургаалыг адилтган ойлгож болохгүй юм. Хэрэв Фреге, Гуссерль хоёрыг харьцуулан үзвэл: сэтгэхүйн объектив агуулга нь бодгалаас хамаардаггүй, хүний сэтгэхүй сэтгэгдэж байгаа юмсыг бүтээдэггүй, харин тэдгээрийг гагцхүү танин барьдаг гэж Фреге үздэг. Түүнийхээр энэ бол хүний эрхэлдэг үйл дотроос “хамгийн нууцлаг зүйл”⁶ мөн. Хэдийгээр Гуссерль психологизмыг шийдвэртэй няцаасан ч субъективизмаас бүр мөсөн ангижирч чадаагүй (эсвэл Гуссерлийн өөрийнх нь үгээр бол «субъективизмыг эрс субъективизмээр л даван туулах боломжтой»). Хүний сэтгэхүйн объектив агуулгыг бүрдүүлж байгаа идеал оршихуй (сэтгэхүйн идеал дүрсүүд) гагцхүү цэвэр ухамсарт оршдог. Өөрөөр хэлбэл, идеал утга ухамсраар дамжин илэрч цаашилбал идеал утгыг догдлон мэдрэх талбар бол гагцхүү ухамсар мөн гэж үзсэн нь Гуссерлийн феноменологи философи бүрэлдэхэд нөлөөлсөн юм. Гэтэл эндээс Гуссерлийн феноменологийн дараагийн чухал асуудал гарч ирэх юм, тэр нь: “Бодитой психик мэдрэмж дотор идеал оршихуй нь хууль юмуу цэвэр ойлголтын байдлаар оролцож, хэрхэн субъектийн танин мэдэхүйн үр дүн болж чадах вэ?”⁷. Идеал оршихуйг сэтгэгч субъектийн харилцаанд объектив байдлаар хэрхэн нотолж болох вэ? (объектив санаа субъектив санаа хоёр ямар харилцаатай вэ?).

Дээрхи асуудлыг тодруулах зорилгоор ухамсрын тухай феноменологи ойлголтыг Гуссерль томъёолсон юм. «Логикийн судалгаа» зохиолд Гуссерлийн Би хэмээх ойлголт нь “үл мэдэгдэх субьектэд” хамаардаг⁸. Энд яригдаж байгаа Би, ухамсар зэрэг ойлголт бол бусад физик юмсын нэгэн адил бие махбод биш, эмпирик Би биш, эмпирик Би-тэй холбоотой оюун санаалаг Би ч бас биш юм. Өөрөөр хэлбэл ухамсрын аливаа туршлагын төв болж байдаг Би хэмээх зүйл Гуссерлийн үзлээр байдаггүй. Тэрээр ухамсрын аливаа туршлагыг (сэтгэхүй, төсөөлөл, хүсэл бодол, гэх мэт ухамсрын бүх модусыг) «догдлон мэдрэхүй» хэмээх үгээр илэрхийлж, «би бол олон янзын догдлон мэдэрхүйгээс

дээш гарсан ямар нэгэн онцгой зүйл бөгөөд чухамдаа бол догдлон мэдэрхүйн нэгдэл мөн»⁹ гэж тэмдэглэсэн нь юмсыг хүртэхүйн нэг агшин нөгөөдөө холбогдож буй догдлон мэдэхүйн цогц холбоог Би буюу ухамсар гэж ойлгоход хүргэж байгаа юм.

Феноменологи утгаар аливаа догдлон мэдэхүй буюу ухамсарт шууд өгөгдөгч нь илт чанартай байдаг. Ухамсарт шууд өгөгдөгчийг урьдаас тогтоосон нөхцөлгүй шууд тоочин илэрхийлэх ёстой. Үүнийг Гуссерль «Логикийн судалгаа» зохиолынхоо эхэнд феноменологийн үндсэн уриа болгон «юмст өөрт нь буцаж үзэх»¹⁰ гэж томъёолсон байна.

Ухамсрын догдлон мэдрэхүй буюу ухамсрын бүх үйл интенционал шинжтэй гэж Гуссерль үздэг. Түүний ийм үзэлд Brentano нөлөөлсөн. Гэхдээ Brentanoгийн бүх «психик феномени» тодорхойлогч гол шинж бол интенционал шинж гэсэн үзэл нь нэг талаас төөрөгдөл юм гэж Гуссерль шүүмжилсэн байдаг. Учир нь Гуссерлийнхээр бүх психик феноменууд биш, харин зарим чухал психик феноменууд л интенционал шинжтэй ажээ. Brentano өөрийн зохиолдоо: “судлагдахууны интенционал (эсвэл ментал) дотоод оршихуй гэж дундад зууны схоластиктуудын нэрлэсэн тэр зүйлээр сэтгэцийн аливаа үзэгдэл тодорхойлогддог бөгөөд бид түүнийг агуулгад хандах хандлага, объектод (үүнийг бодит байдал гэж андуурч болохгүй юм) чиглэсэн байдал аль эсвэл имманент судлагдахуун хэмээн давхар утгаар мөн илэрхийлэхээр байлаа. Сэтгэцийн аливаа үзэгдэл ... объект болох ямар нэгэн юмыг өөртөө агуулж байдаг. Төсөөлөлд ямар нэгэн юм төсөөлөгддөг, бодомж нь ямар нэгэн зүйлийг нотолдог аль эсвэл няцаадаг ... гэх мэт”¹¹ гэж бичжээ. Интенционал шинжийн тухай Brentanoгийн уг санааг Гуссерль хүлээн авсан боловч феноменийг сэтгэгцээр (психофизик амьдралаар) нөхцөлдсөн имманент судлагдахуун гэж ойлгох бололцоогүй гэж үзсэн байна. Учир нь Brentano субъектийн тухай уламжлалт

⁶ Гуссерль Э. Логические исследования. // Гуссерль Э. Сборник. - Мн., - М., 2000. - С. 69.

⁷ Там же. - С. 137.

⁸ Фреге Г. Логика и логическая семантика: Сборник трудов. - М., 2000. - С. 36.

⁹ Гуссерль Э. Избранные работы. // Логические исследования: Исследования по феноменологии и теории познания. Том II. - М., 2000. - С. 85.

¹⁰ “Психология без души” гэдгийг ийнхүү орчуулав.

¹¹ Гуссерль Э. Избранные работы. // Логические исследования: Исследования по феноменологии и теории познания. Том II. - М., 2000. - С. 138.

үзэл санааг баримтладаг. Харин Гуссерль интенционал догдлон мэдэрхүйг «үйл»¹² хэмээх үгээр тэмдэглэж, энэ нь субъектив үйлдэл гэсэн утга заадаггүй гэсэн байна. Үйлдэл нь тодорхой субъектын тухай санааг бий болгодог боловч Гуссерлийн боловсруулсан ухамсар, Би гэх зэрэг ойлголтуудад субъектийн тухай уламжлалт ойлгоц байхгүй юм. «Хэрэв бид фантазилах, үлгэр унших, математикийн нотолгоо гаргах зэрэг үйл явдлуудыг авч үзвэл Би-гийн үйлдэлтэй холбоотой ямар ч төвийг сэрж мэдрэхгүй юм»¹³. Феноменологийн шинжилгээ нь психик үйл ажиллагаа биш, харин субъектээс үл хамааран ойлгогддог үйлүүдийг судлахад чиглэсэн байдаг. Гуссерль хожмын бүтээлүүддээ үүнийг «цэвэр ухамсар» гэж томъёолж, түүнд редукцийн (ялангуяа эмпирик психологийн Би-гийн тухай ойлгоцоос чөлөөлөх трансцендентал редукцийг онцолсон байна) тусламжтай хүрнэ гэж үзсэн юм.

Гуссерлийн хувьд феноменологийн шинжилгээ хэлтэй нягт холбоотой. Учир нь хэл бол феноменологи туршлага бий болох чухал нөхцөл юм. Хэл сэтгэхүй хоёр нягт холбоотой гэж Гуссерль үзсэн нь санамсаргүй хэрэг биш билээ. «Оюун санааны илүү өндөр түвшинд хамаарах бодол эргэцүүлэл хэлний илэрхийлэлгүйгээр (хэллэг) боломжгүй»¹⁴. Харин феноменологи үзлийн үүднээс хэл өөрийн физик мөн чанарын хязгаараас цааших зүйлсийг илэрхийлж чаддаг ажээ. «Тодорхой психик үйлд өгүүлэгч этгээд утга оноосон тэр нөхцөлд өгүүлсэн авианы цуглуулага (эсвэл бичиж тэмдэглэсэн зүйлс) үг болж хувирна». Иймд хэлний илэрхийллийн утга ухамсарт бий болох оюун санаалаг дүртэй холбоотой тайлбарлагдах юм. Үүнийг «утга оноох үйл»¹⁵ гэж Гуссерль нэрлэдэг. Гэхдээ утга оноож байгаа үйлийн үр дүнд ямар нэгэн зохиомол зүйл бий болдог гэж Гуссерль үзээгүй. Аливаа илэрхийллийг ойлгоход бодож зохиосон дүр хэрэггүй. «Соёл», «дифференциал тоолол», «мянган талтай олон өнцөгт» гэх мэт үгст ямар дүр холбоотой байж болох вэ? Түүнээс гадна

психик дүрээр нөхцөлдсөн үзэгдэлтэй холбож хэлний илэрхийлэлүүдийг ойлгодог гэж үзэх юм бол тийм дүрүүд оршин байх нь юуг ч тайлбарлахгүй. Тэгвэл «утга оноох үйл» ямар үүрэгтэй гэж үзэж болох вэ?

Гэхдээ ухамсрын үйл хэлний илэрхийллийн утгатай адил биш. Учир нь янз бүрийн илэрхийлэл ашиглаж олон янзын интенциэр нэг л утгыг олон дахин давтан бүтээж болно. Тухайлбал, «Иенид ялагч», «Ватерлоод ялагдагч» хэмээх илэрхийлэлүүд Наполеоныг буюу Гуссерлийн хэллэгээр тэр идеал оршихуйг янз бүрээр илэрхийлсэн байдал юм. Илэрхийлэл тус бүрт «утгын интенци» өөр өөр байдлаар хэрэгжиж байна. Яг ийм маягаар «гурвалжны бүх өндөр нэг цэгт огтолцдог» хэмээх илэрхийлэлд бичигдсэн, өөрөө өөрөөрөө байгаа царцанги тэмдэгүүд үнэн хэрэгтээ ухамсрын интенциэр хэлхэгдэж бид уг илэрхийллийн утгыг ойлгож мэддэг. Ухамсрын ийм интенци үүсэж устдаг ч илэрхийллийн илэрхийлж буй зүйл, өөрөөр хэлбэл «гурвалжины бүх өндөр нэг цэгт огтолцдог» гэсэн өгүүлбэрийн агуулга үүсэж устдаггүй. Сэтгэж болох олон бололцоотой үйлдэлд түүний утга буюу идеал оршихуй эсрэгцэж байдаг. Утга бол бидний бодол санаанд (утга оноох үйлд) хэрэгжиж байгаа ерөнхий зүйл мөн. Нэгж, субъектив үйлдэлтэй харьцуулахад утга ерөнхий шинжтэй, ерөнхий зүйл юм. Тэгэхдээ Гуссерлийн үзлээр ерөнхий юмс обьектив ертөнцөд ч, бурхан тэнгэрлэг оюун ухаанд ч оршдоггүй учир тэдгээрийг метафизик хийсвэрлэл болгох нь феноменологийн үүднээс утгагүй билээ.

Тийнхүү Гуссерлийн үзлээр цэвэр ухамсар ертөнцийн утгыг бүтээдэг. Утга (эйдос) бол субъектив психик үйл явцаас ялгаатай цэвэр ухамсарт орших обьектив агуулга бөгөөд энэ нь интуицид л өгөгддөг байна. Гэхдээ энэхүү үзэл философийн түүхэнд урьд өмнө огт байгаагүй цоо шинэ үзэгдэл биш гэж нэрт феноменологич Р.Ингарден үзэж, Ж.Локкийн философийг онцлон тэмдэглэсэн юм. Түүнийхээр Ж.Локкийн сургаалд трансцендентал феноменологийн чухал санаа бий¹⁶. Учир нь энд «юмс» гэдэг нь зөвхөн хүний сэрэл мэдрэмжээр бий болсон өгөгдөхүүн биш,

¹² "back to the things themselves" гэдгийг ийнхүү орчуулав.

¹³ Brentano Ф. Психология с эмпирической точки зрения. // Brentano Ф. Избранные работы. - М., 1996. - С.33.

¹⁴ "Акт" гэдгийг ийнхүү орчуулав.

¹⁵ Гуссерль Э. Избранные работы. // Логические исследования: Исследования по феноменологии и теории познания. Том II. - М., 2000. - С.143.

¹⁶ Там же. - С. 79

харин сэрлийн тухай ерөнхий санаа юм¹⁷. Ингарден болон бусад феноменологчидын үзснээр уг нарийн шүтэлцээг Локк өөрөө ч ойлгоогүй ажээ. Хэрэв + ийм дүрс байлаа гэхэд хүмүүс түүнийг эртний бичиг, загалмай гэх мэт янз бүрээр тайлбарлахыг оролдох юм. Энд өгөгдөхүүн нь нэг боловч ухамсар түүнд өөр өөр «утга оноож» байна. Тийнхүү феноменологчдын үзлээр перцептив хүртэхүй нь концепци буюу утга агуулгатай байдаг бөгөөд энэ нь ухамсрын интенционал шинжтэй холбоотой юм. Ухамсрын интенцид өртөж буй объект бол гадаад ертөнцийн юм биш, харин ухамсрын өөрийнх нь бүтээгдэхүүн байдаг. Тиймээс ухамсрын интенцийн агуулга зөвхөн тэмдэглэгдэгчийн “матери”-иар хязгаарлагддаггүй (хүн төрлөхтөний мэдлэгийн нэг чухал хэлбэр гэж тооцогддог эртний мифүүдийг утгагүй зүйл гэж үздэггүй нь үүний нэг жишээ юм). Тиймээс сэрэл нь объектыг хүртэхэд зайлшгүй боловч хангалтгүй. Ертөнцийг танин барих ухамсрын үйлд «идеал утга» (мөн чанар-эйдос) гарцаагүй хэрэгждэг бөгөөд сэрэл, дүрслэл, төсөөлөл, хүсэл, бодол зэрэг ухамсрын бүх модусын чинад (трансценденци) оршдог туршлагын утгын бүтцийг феноменологи судалдаг гэж дүгнэж болох юм.

Ухамсрыг «интенционал шинж»-тэй холбон тайлбарласан Гуссерлийн үзэл нь ухамсрын тухай бусад уламжлалт болон уламжлалт бус философи сургаалаас ялгаатай. Сонгодог философийн зарим сэтгэгчид танин мэдэхүйн үйл бүрийг ухамсартай холбож, ухамсрыг мэдлэгтэй адилтгаж, иймд бидний ухамсарлаж буй бүх зүйл мэдлэг мөн (орос хэлээр со-знание) гэдэг байр суурины үүднээс асуудалд хандсан байдаг. Тодруулбал, Кантын үзлээр “миний бүх төсөөлөлийг “би сэтгэж байна” гэдэг нь дагалдах боломжтой байх ёстой”¹⁸, эс тэгвээс мэдлэгийн тухай ярих боломжгүй болно. Тэгвэл XIX зууны зарим философчид шинжлэх ухаан зөвхөн ухамсрын үзэгдлүүдийг л судлах боломжтой бөгөөд тэдгээр нь догдлон мэдрэхүйд субъектив байдлаар өгөгддөг ч ухамсрын субстанцийг өөрийг нь илэрхийлэх бололцоогүй гэж үздэг.

¹⁷ “Актов придания значения” гэдгийг энд ийнхүү орчуулав

¹⁸ См. Ингарден Р. Введение в феноменологию Эдмунда Гуссерля: Лекции 1967 г. в Осло. - М., 1999.

Тухайлбал, Вильгельм Вундт ухамсрын тухай ийм функционалист байр суурийг баримтладаг. Түүний үзлээр «ухамсар бол ухамсарлагдаж буй төлөвүүдийн цогц мөн»¹⁹ билээ.

Гуссерль болон түүний үзлийг дэмждэг бусад феноменологчдийн үзлээр ухамсрын гол шинж бол дискурсив байдал биш, харин «интенционал шинж» мөн гэж бид дээр өгүүлсэн. Уг шинж зөвхөн сэтгэхүй төдийгүй хүртэхүй, төсөөлөл, сэтгэлийн хөдөлгөөн, хүсэл зориг зэрэгт (өргөн утгаар бүх догдлон мэдрэхүйд) хамаардаг. Хэрэв ямар нэгэн зүйл ухамсрын интенционал объект болоогүй бол тэр юмны тухай бид юу ч мэдэх боломжгүй. Эл үзлийн үүднээс ухамсар бол интенцийн цогц төдийгүй түүний эх сурвалж билээ. Цаашилбал «интенционал шинж» хэмээх ойлголтоор дамжуулж тэд ухамсар, психик хоёрыг адилтгасан нь XX зуунд хөгжсөн сэтгэл, ухамсрын тухай философи баримтлалуудаас агуулга болон арга зүйгээрээ мөн ялгаатай юм. Тухайлбал, хүний сэтгэцийн шинэ загварыг философи, сэтгэл судлалын салбарт санал болгосон психоанализын үндэслэгч З.Фрейдийн үзлээр хүний санаалаг ертөнцийг бүхэлд нь ухамсаргүй сэтгэл тодорхойлж байдаг. Тиймээс психик феноменууд бүрэлдэхэд ухамсаргүй сэтгэл шийдвэрлэх үүрэгтэй гэж үздэг. Психоанализ төдийгүй ухамсар, санааг авч үздэг бусад үзэл баримтлалын агуулгын нийтлэг тал нь хүний психофизик амьдралыг судалдаг бол, арга зүйн хувьд тэнд натурализм давамгайлж байдаг. Гэтэл Гуссерль ухамсар, санааг натуралчлах хандлагыг эрс шүүмжилж, хүний психофизик амьдралаар нөхцөлдсөн сэтгэцийн үзэгдлийн тухай биш, харин трансцендентал феноменологийн түвшинд догдлон мэдрэхүйн үр дүнд бий болсон психик феномены тухай ярьсан юм. Англи хэлтэй орнуудад феноменологийг танилцуулах зорилгоор «The Encyclopaedia Britannica»-д Гуссерль феноменологийн тухай өгүүлэл бичиж нийтлүүлсэн. Тэнд феноменологийг “априори психологийн ухаан” гэж тодорхойлсон байна[□]. Тиймээс ухамсрын тухай Гуссерлийн сургаалыг санаалаг ертөнцийг судалдаг бусад философи баримтлалуудтай аргагүйн хувьд

¹⁹ “Ideas of sensation” гэдгийг ийнхүү орчуулав

шууд жишин ойлгож болохгүй юм. Түүхэн баримтыг сөхөн үзвэл Гуссерль, Фрейд хоёр Brentanoгийн шавь байсан бөгөөд нэг нь цэвэр ухамсрын тухай, нөгөө нь ухамсаргүй сэтгэлийн тухай сургаалыг тус тус хөгжүүлжээ.

Гуссерлийн үзлээр «феноменологи бол ухамсрын мөн чанарын тухай шинжлэх ухаан» юм. Ухамсрын үйл²⁰ бол имманент туршлага, ухамсарлахуй мөн. Ийм учраас ухамсар интенционал шинжтэй. Ухамсрын үйлдэл ямар нэгэн объектын утгыг бүтээж байдаг. Тэр утга буюу эйдосыг бид интуицээр л танин мэддэг юм.

НОМ ЗҮЙ:

1. Brentano Ф. Психология сэмпирической точки зрения. // Brentano Ф. Избранные работы. - М., 1996
2. Вундт В. Введение в психологию. - СПб., 2002
3. Гуссерль Э. Избранные работы. - М., 2005
4. Гуссерль Э. Сборник. - Мн. - М., 2000
5. Гуссерль Э. Феноменология: Статья в Британской энциклопедии. // "Логос". 1/ 1991.
6. Ингарден Р. Введение в феноменологию Эдмунда Гуссерля: Лекции 1967 г. в Осло. - М., 1999
7. Кант И. Критика чистого разума. - СПб., 1993
8. Милль Д. С. Система логики силлогистической и индуктивной: Изложение принципов доказательства в связи с методами научного исследования. - М., 2001
9. Фреге Г. Логика и логическая семантика: Сборник трудов. - М., 2000
10. Шпигельберг Г. Феноменологическое движение. Историческое введение. - М., 2002
11. David Woodruff Smith. Husserl. - USA., 2007

ABSTRACT

This article deals with some aspects of Husserl's Logical Investigations. In this book he assumed ideal meaning and their logical correlations with basic form of objects; then he outlined a theory of ideal species, followed by the theory of part-whole structures; then he turned to the intentional relation of consciousness to its objects, looking into the role of ideal contents or meaning in intentional experience. So one can say that, in the Logical Investigations Husserl worked from logic to philosophy of language, to ontology, to phenomenology and to epistemology. The structure of intentionality is central to the analysis of conscious experience in Husserl's phenomenology.

²⁰ Кант И. Критика чистого разума. - СПб., 1993.- С. 98.